

ХОЁРДУГААР АЖЛЫН ХЭСЭГ- 1 дүгээр хуралдаан
 2015 оны 3 дугаар сарын 23- ны 15,00 Уул уурхайн яамны 2 дугаар давхарын Хурлын танхим
 Ирц:

	Албан тушаал	Нэр	Ирсэн/Ирээгүй бол тайлбар
1	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны ХБОНГ-ын ахлах мэргэжилтэн	Б.Саран	Хурал давхацсан
2	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын ГУУ-ын улсын ахлах байцаагч	Ц. Мөнхцэцэг	Утас хаалттай
3	Уул уурхайн яамны СБТГ-ын мэргэжилтэн	Т.Зууннаст	Ирсэн
4	Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч	Н.Алгаа	Ирсэн
5	Монполимет ХХК-ийн гүйцэтгэх захирал	С.Энхтуяа	Ирсэн
6	Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын ТУЗ-ын гишүүн	Л.Долгормаа	Амжихгүй болов.
7	Хөвсгөл далайн эзэд ТББ-ын тэргүүн	Б.Баярмаа	Эмнэлэгт
8	Байгаль орчны аудитын холбооны Удирдах зөвлөлийн дарга	Д.Энхээ	Утас хаалттай
9	МБОИЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн	Б.Батболд	Утас хаалттай
10	Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбоо	Ц.Туяацэцэг	Өмгөөлөгч ирүүлнэ гэсэн, ирээгүй
11	ОУИТБС-ын ажлын албаны зохицуулагч	Ш.Цолмон	Ирсэн

Хуралд ирсэн гишүүд саналаа хэлцгээв.

Н.Алгаа-Байгаль орчныг хамгаалах ба нөхөн сэргээх ажил 5 үе шаттайгаар явагддаг. Нэгдүгээрт, байгаль орчны ерөнхий ба нарийвчлсан үнэлгээ хийлгэх, хоёрдугаарт, үүн дээр үндэслэн байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон тухайн жилд гаргах зардал батлуулах, гуравдугаарт, барьцаа байршуулах, дөрөвдүгээрт, нөхөн сэргээлт хийвэл барьцааны хөрөнгөө буцаах, эцэст нь нөхөн сэргээлт хийж хүлээлгэж өгөх, хүлээн авах гэсэн тогтолцоотой. Хоёр жилийн өмнөөс аудит хийдэг болсон. Байгаль орчны үнэлгээг буруу хийдэг байсан. “Copy/Paste” маягтайгаар үнэлгээг хийж, ихэнх нь муу хийж ирсэн. Үнэлгээ хийх эрх бүхий 130 орчим компани байдаг, Төлөвлөгөөгөө муу хийж, бага төлөвлөж ирсэн, өөрөөр хэлбэл замбараагүй байгаа хэлж болно. Аудит хийхэд байгаль орчны үнэлгээ ихэнх тохиолдолд бодит байдалтай нийцэхгүй байгаа нь ажиглагдаж эхэлсэн.

С.Энхтуяа- Байгаль орчны төлөвлөгөөг батлахын өмнө урьдчилгаа мөнгийг заавал байршуулахыг шаарддаг. Жил болгон барьцаа байршуул гэдэг, гэвч аль болох бага хөрөнгийг байршуулахыг ихэнх компаниуд эрмэлздэг. Их мөнгө байршуулбал хүүний зардал нэмэгдэж, үргүй зардал нэмэгдэхээр байдаг тул өөрсдөө нөхөн сэргээлт хийдэг. Ойролцоогоор 700 сая орчим төгрөгийн

нөхөн сэргээлт жилд хийж, мөнгөө харин буцааж авдаггүй, учир нь 2, 3 хан сарын дараа дахин мөнгө байршуулах шаардлага үүсдэг юм. Гол санаа нь хөрөнгийг үр ашиггүй зарцуулахаас сэргийлэх үүднээс 1 жилийн дараа тооцдог болох хэрэгтэй байна. Төлөвлөгөөг батлуулахын өмнө аймаг сумдын удирдлагаас бичиг авах зэргээр хүнд сурталтай.

Н.Алгаа- Байгаль орчины нөхөн сэргээлтийн бүх барьцааг заавал тулган баталгаажуулах шаардлагагүй. Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий компаниудын барьцаа хөрөнгийг тулган баталгаажуулах, харин хайгуулын барьцааг орхисон ч болно шүү. Ерөөсөө байгаль орчины нөхөн сэргээлтийн суурь бүтцийг жижиг жижиг дэд бүтцээр яаж сайжруулах вэ гэдгийг яримаар байна.

Т.Зууннаст- Барьцааны хөрөнгийг ашиглалт, хайгуул гэдгээр нь ил тод мэдээлж байх нь зүйтэй. Талбай хичнээн том байна, төдий чинээ барьцаа хөрөнгө их байх магадлалтай.

Н.Алгаа- Хайгуулыг заавал ухаад, сүйтгэхгүйгээр хийх технолог аль хэдий нь гарсан, сансар, соронзон орны арга гээд, тиймээс зардал бага байхаас өөр аргагүй байдаг талтай. Өнөөгийн аргачлал нь ордын онцлогийг тооцоогүй учир бодит нөхөн сэргээлт болсон гэж тооцоход бэрхшээлтэй юм.

С.Энхтуяа- Шалгуур- критерүүдийг тодорхой болгох ёстой. Ордын ашиглалт хэдэн жил болох, арга нь ямар байх гээд олон зүйлийг сайжруулах нь зүйтэй байна.

Тохирсон нь:

1. Оролцогч нар асуудлын мөн чанарыг дахин нягталж нэмэлт мэдээлэл гаргана.
2. Ажлын албанаас барьцааны хөрөнгийн судалгааг ангилж дараагийн хуралд танилцуулах

Тэмдэглэл хөтөлсөн Ш.Цолмон